



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/792

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Халуун усны барилгын гадна шугам сүлжээний (Баян-Агт сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Олзмандал” ХХК-тай 83 487 223 (наян гурван сая дөрвөн зуун наян долоон мянга хоёр зуун хорин гурав) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.“Олзмандал” ХХК-ийн ажлын гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Олзмандал” ХХК-ийн захирал (Ц.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

0328810941

Аймгийн Засаг даргын 2023 оны  
11 дугаар сарын 27-ны өдрийн  
1792 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Дүн	Хариуцах албан тушаалтан
1.	Ажил гүйцэтгэх хугацаа	40 хоног	Ү.Бямбасүрэн
2.	Нормчлолын сан	127 302	Ү.Бямбасүрэн
3.	Захиалагчийн техник хяналтын зардал	1 414 470	Ү.Бямбасүрэн
4.	Зургийн зардал	1 727 900	Ү.Бямбасүрэн
5.	Зураг төсөл зохиогчийн зардал	707 236	Ү.Бямбасүрэн
6.	Магадлашгүй ажлын зардал	1 414 470	Ү.Бямбасүрэн
7.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь	Хоногт гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0,1 хувь байна. Нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувиас ихгүй байна.	Д.Батцогт
8.	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна	Д.Батцогт